


 БАТЛАВ
 ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
 ХОШУУЧ ГЕНЕРАЛ
 Т.БАДРАЛ

2020 оны 01 дүгээр сарын 10 ны өдөр

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2020 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Авлигын эсрэг хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сурталчилах, Онцгой байдлын байгууллагад авлига, ашиг сонирхол, хүнд суртал үүсэх нөхцөл, эрсдэлийг бууруулж, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, ил тод, нээлттэй үйл ажиллагааг эрчимжүүлэх, бэхжүүлэх, олон нийтийн эрх ашгийг дээдэлж, алба хаагчдад шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, авлигаас ангид байлгахад оршино.

д/д	Үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үзүүлэлт		Хариуцах нэгж	Хүрэх үр дүн
			Хэрэгжүүлэх хугацаа	Шаардагдах зардал		
Нэг. “ШУДАРГА, ХАРИУЦЛАГАТАЙ, ИЛ ТОД БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ” хүрээнд:						
1.	Авлигын эрсдэл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх	1.1.1. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг төлөвшүүлэх.	Жилдээ	-	ЗУГ-ЗХНХ	Онцгой байдлын байгууллагын хүний нөөцийг ил тод байдлаар шударгаар бүрдүүлж, мэргэжлийн чадварлаг алба хаагчид бүрдүүлнэ.
		1.1.2. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй сургалтад алба хаагчдыг хамруулах.	Жилдээ	-	ЗУГ-ДАХТ	Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын авлигын эсрэг мэдлэг дээшилнэ.
		1.1.3. Онцгой байдлын байгууллагаас зохион байгуулах сургалтуудад Авлигатай тэмцэх газар болон хууль, хяналтын байгууллагын холбогдох албан тушаалтнаар Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх хууль тогтоомжийн тухай сургалт, яриа таниулга хийлгэх.	Жилдээ	-	ЗУГ-СХ	
		1.1.4. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, үүрэг, оролцоо, идэвх санаачилгыг дэмжих, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, түүнд хяналт тавих.	Жилдээ	2,000,000	ЗУГ-ДАХТ, ТОНОББ	
		1.1.5. Зөрчил, дутагдал гаргасан албан тушаалтанд сонсох ажиллагаа явуулах, энэ талаар өөрт нь мэдэгдэж, тайлбар гаргах боломжийг хуульд заасны дагуу олгох.	Тухай бүр	-	ЗУГ-ЗХНХ	Онцгой байдлын байгууллагын

		1.1.6. Албан тушаалтанд ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг танилцуулах, дахин зөрчил, дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.	Тухай бүр	-	ЗУГ-ЗХНХ	 <p>алба хаагчдын албандаа хандах хандлага, хариуцлагын тогтолцоо бэхжинэ.</p>
		1.1.7. Алба хаагчдын зүгээс хуулиар зөвшөөрөгдсөн давхар ажил эрхлэх тохиолдолд зөвшөөрөл олгох, энэ талаарх мэдээллийг өгөх, хяналт тавих.	Тухай бүр	-	ЗУГ, ТОНОББ	Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн аиг сонирхлын зөрчлийг зохицуулах тухай хуулийн хэрэгжилт хангагдана.
		1.1.8. Алба хаагчдын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг нэгтгэн, тайланг хуулийн хугацаанд Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх.	I улирал	-	ЗУГ-ДАХТ	
Хоёр. “ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАЖ, ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ” хүрээнд:						
2.	Байгууллагын нээлттэй байдал, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдлэх	2.2.1. Гамшгаас хамгаалах тухай болон шинээр батлагдан гарсан хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг алба хаагчдад сурталчилах,	Жилдээ	2,000,000	БЗХАГ-СБТХ, ГУСГ-ОНХТ	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилт хангагдана.
		2.2.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгжээс хийх шалгалтын төлөвлөгөөг цахим хуудсаар мэдээлэх, хяналт шалгалтыг зохион байгуулах	Тухай бүр	-	ДХШАБГ	Дотоод хяналт, шалгалт сайжирч, байгууллагын үйл ажиллагаа шуурхай болж, алба хаагчдын шударга байдал дээшилнэ.
		2.2.3. Авлигын эсрэг мэдээлэл хүлээн авах тусгай дугаарт ирсэн мэдээллийг бүртгэлжүүлэн холбогдох арга хэмжээг авах.	Жилдээ	432,000	ЗУГ-ДАХТ	Авлигын эсрэг хууль, тогтоомжийг сурталчилах, олон нийтийг мэдээллээр хангана.
		2.2.4. Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааны талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бичгээр болон цахим сүлжээгээр санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авах боломжийг бүрдүүлж, шуурхай шийдвэрлэж ажиллах.	Тухай бүр	-	ЗУГ-ДАХТ	
		2.2.5. Онцгой байдлын байгууллагын сул орон тооны зар, сонгон шалгаруулалт явуулах талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулах, удирдлагын ил тод байдлыг хангах.	Тухай бүр	-	ЗУГ-ЗХНХ, ГУСГ-ОНХТ	Хүний нөөцийг ил тод, шударгаар бүрдүүлж, мэргэжлийн чадварлаг алба хаагчид бүрдэнэ.
Гурав. “ТӨСӨВ, САНХҮҮ, АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ” хүрээнд:						

3.	Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх	3.3.1. 2019 оны төсвийн гүйцэтгэл, жилийн эцсийн санхүүгийн тайлан, 2020 оны төсөв, 2021 оны төсвийн төсөл, 2020 оны төсөвт орсон өөрчлөлт /ороогүй бол мэдээллэх/, төсвийн орлого бүрдүүлэлтийн мэдээлэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт зэргийг хуульд заасан хугацаанд цахим хуудсанд байршуулах.	II, IV улирал	-	СХХОГ-СХОХ, ГУСГ-ОНХТ	Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдаж, санхүүгийн нээлттэй, ил тод байдал хангагдана.
		3.3.2. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг холбогдох хуулийн хүрээнд цахим хуудсанд байршуулах.	Тухай бүр	-	СХХОГ-СХОХ, ГУСГ-ОНХТ	
		3.3.3. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалт гаргаж цахим хуудсанд байршуулах.	I улирал	-	СХХОГ-СХОХ, ГУСГ-ОНХТ	
		3.3.4. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг ил тод, нээлттэй байлгах, иргэдийн хэрэгцээ хангахуйц мэдээллийг байгууллагын самбарт байрлуулах.	Улирал тутам	-	БЗХАГ-ГХАХ, СХХОГ, ГУСГ-ОНХТ	
		3.3.5. Олон улсын болон дотоодын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, хуваарилах ажлыг олон нийтэд ил тод байлгаж хэвлэл мэдээлэл, цахим хуудсаар мэдээлэх.	Тухай бүр	-	УНХТГ, ГУСГ-ОНХТ	
		3.3.6. Шилэн дансны бүртгэл, мэдээллийг хуулийн хугацаанд тайлагнах, түүнд хяналт тавих.	Улирал тутам	-	СХХОГ-СХОХ, ДХШАБГ	
4.	Худалдан авах ажиллагааны үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх	3.4.1. Худалдан авах ажиллагааны 2020 оны төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлэх, тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлах, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, 2020 оны худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт зэргийг хуульд заасан хугацаанд цахим хуудсанд байршуулах.	Тухай бүр	3,000,000	СХХОГ-ХҮХ, УНХТГ, ГУСГ-ОНХТ	
		3.4.2. Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулж, хяналт, хариуцлагыг сайжруулах.	Тухай бүр	2,500,000	СХХОГ-ХҮХ, УНХТГ, ГУСГ-ОНХТ	
5.	Нийт 4 чиглэлийн 21 арга хэмжээ		Нийт зардал 9,932,000. төгрөг			